



САНХҮҮГИЙН  
ЗОХИЦУУЛАХ ХОРОО  
FINANCIAL REGULATORY COMMISSION  
OF MONGOLIA

2021 ОНЫ ЭХНИЙ ХАГАС  
ЖИЛ



ТАЙЛАНГИЙН  
НЭГТГЭЛИЙН  
ТАНИЛЦУУЛГА

САНХҮҮГИЙН БУС БИЗНЕС,  
МЭРГЭЖЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ  
ҮЗҮҮЛЭГЧ



#Санхүүгийнзохицуулаххороо

# Агуулга

Оршил

Хууль, эрх зүйн зохицуулалт

Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага

Статистик үзүүлэлт

Борлуулалтын тойм

Санхүүгийн тайлангийн үзүүлэлт

Эрсдэлийн үнэлгээ

Дүгнэлт

Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч

Статистик үзүүлэлт

Борлуулалтын тойм

Санхүүгийн тайлангийн үзүүлэлт

Эрсдэлийн үнэлгээ

Дүгнэлт

Нэгдсэн дүгнэлт

1

2

3

4

5



---

## НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

СЗХ - Санхүүгийн зохицуулах хороо

ҮХЭХЗБ - Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага

ҮМҮЧЭТХЭАЭ - Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч

МУТСТ - Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх



## ОРШИЛ

Санхүүгийн бус бизнес мэргэжлийн, үйлчилгээ үзүүлэгчид буюу үл хөдлөх хөрөнгө зуучлалын байгууллага болон үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчид нь манай улсын нийгэм-эдийн засагт чухал нөлөө үзүүлсээр ирсэн боловч аливаа зохицуулалтгүй, статистик тоон мэдээлэлгүй, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх тогтолцоогүй байсан. Иймд Монгол Улсын Их Хурлын 2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулж санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйл ажиллагаа болох үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын болон үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаанд хамааруулан зохицуулах, хяналт тавих үүргийг Санхүүгийн зохицуулах хороо хэрэгжүүлэхээр хуульчлагдсан.<sup>1</sup>

Хуулиар олгосон чиг үүргийн хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл, бүртгэл, хяналттай холбоотой харилцааг зохицуулсан журмуудыг баталж, тусгай зөвшөөрөл олгож бүртгэлжүүлэн хянаж, зохицуулж байгаа ба зохицуулалтын салбарын мэргэжлийн холбоодод тавигдах шаардлагыг тодорхойлсон журмыг баталж, салбар тус бүрийн мэргэжлийн холбоодтой сургалтын чиглэлээр хамтран ажиллах гэрээг байгуулан зохицуулалтын зохистой орчин бүрдүүлэх, мэргэжлийн оролцогчдоо чадавхижуулах, мэргэшүүлэх, эрх ашгийг нь хамгаалах талаар хамтран ажиллаж байна.

Энэхүү ажлын хүрээнд хууль тогтоомжид заасан нөхцөл шаардлагын дагуу үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг нийт 205 хуулийн этгээдэд олгож, эдгээр зуучлалын байгууллагууд нь 226 брокер, 1,255 агенттай үйл ажиллагаа эрхлэхээр Хороонд бүртгүүлсэн бол 459 иргэн, хуулийн этгээдэд үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосон байна. Харин тусгай зөвшөөрөл олгох тухай хүсэлтээ Хороонд ирүүлээгүй улсын бүртгэлд бүртгэлтэй 6,728 хуулийн этгээдийн үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын, 230 хуулийн этгээдийн үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн худалдаа эрхлэх үйл ажиллагааны чиглэлийг хүчингүй болгох талаар Улсын бүртгэлийн ерөнхий газартай хамтран ажилласан.

Мөн зайны хяналт, шалгалтын хүрээнд тусгай зөвшөөрөлтэй иргэн хуулийн этгээдээс 2020 оны 6 дугаар сараас эхлэн тайлан нэгтгэлийн Фин-А системээр холбогдох тайлан мэдээг хүлээн авч хянан баталгаажуулан ажиллаж байгаа бөгөөд “Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйл ажиллагааны тайлангийн нэгтгэлийн танилцууллага”-ыг 3 дахь удаагаа бэлтгэн олон нийтэд мэдээлж байна.



## Ерөнхий төлөв байдал

# 2021.11

## 205

Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага

## 453

Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч

## 103

Нийт ирүүлсэн хүсэлтийн тоо



ТЗ 54



ТЗ 21

Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага

Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч нар

## 11

Брокер, агентын өөрчлөлт

## 6

ХНХ-ийн өөрчлөлт

## 1

ГЗ-ийн өөрчлөлт

## 10

Бусад



Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж буй этгээдээс ирүүлсэн хүсэлт, тусгай зөвшөөрөл шинээр хүсэж ирүүлсэн баримт бичгийг холбогдох хууль, журамд нийцүүлэн дараах байдлаар хянаж, шийдвэрлэсэн байна.

ТЗ хүсэлт

## 61%

Брокер, агентын өөрчлөлт

## 100%

ХНХ-ийн өөрчлөлт

## 71%

ГЗ-ын өөрчлөлт

## 100%

Хаяг байршил, өөрчлөлт, нэмэлт үйлчилгээ

## 100%



## Хууль, эрх зүйн зохицуулалт

	Тогтоолын дугаар, өдөр	Журам, зохицуулалт
2020 он	2020 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн 120 дугаар тогтоол	Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олголт, бүртгэлийн журам
	2020 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн 121 дүгээр тогтоол	Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагаас төвлөрүүлэх зохицуулалт үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох тухай
	2020 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 150 дугаар тогтоол	Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олголт, бүртгэлийн журам
	2020 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 151 дүгээр тогтоол	Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчээс төвлөрүүлэх зохицуулалт үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох тухай
	2020 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн 179 дүгээр тогтоол	Банкнаас бусад санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлох журам
	2020 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн 181 дүгээр тогтоол	Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам
	2020 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн 182 дугаар тогтоол	Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам
2021 он	2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 1048 дугаар тогтоол	Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн мэргэжлийн холбоонд тавигдах шаардлагыг тодорхойлох журам
	2021 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 152 дугаар тогтоол	Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын мэргэжлийн холбоонд тавигдах шаардлагыг тодорхойлох журам
	Хорооны 2020 оны 181 дүгээр тогтоолоор баталсан “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам” болон Хорооны 2020 оны 182 дугаар тогтоолоор баталсан “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам”-ын шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан 2021 оны 02 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн олон нийтээс санал авсан бөгөөд Хорооны 2020 оны 120 дугаар тогтоолоор баталсан “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олголт, бүртгэлийн журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулж мөн оны 02 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн олон нийтээс санал авсан.	



# Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага






Үл хөдлөх хөрөнгийн зах зээл нь эдийн засгийн өсөлт, хүн амын амьжиргааны түвшнээс шууд хамааралтай салбаруудын нэг бөгөөд тус зах зээл нь манай орны ДНБ-ийн 6 орчим хувийг эзэлдэг.

Сүүлийн жилүүдэд үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын чиглэлээр ажиллах боловсон хүчний тоо жилээс жилд нэмэгдэж байгаа бөгөөд цаашид хөрөнгийн менежментийн цогц үйлчилгээ хөгжих хандлагатай байна.



Дэлхий нийтийг хамарсан цар тахал /ковид-19/-ийн улмаас эдийн засгийн хүндхэн үеийг сүүлийн 2 жилийн хугацаанд даван туулж байгаа бөгөөд ялангуяа агаарын тээвэр, олон улсын худалдаа, үйчилгээний салбаруудад давагдашгүй хүчин зүйлсийн нөлөөнд автаж ихээхэн уналтыг үзүүлээд байна. Манай улсын хувьд 2019 онд үл хөдлөх эд хөрөнгийн салбар уналттай байсан бол 2020 онд өмнөх онтой харьцуулахад 0.2 функтийн өсөлттэй байна. Монголбанк 2020 оны 10 дугаар сараас эхлэн ипотекийн зээлийн хүүг 8 хувиас 6 хувь болгон бууруулснаар орон сууцны эрэлтийг дэмжсэн чухал бодлогын шийдвэр болсон бөгөөд нөгөө талаас орон сууцны бүтээн байгуулалт нэмэгдсэн нь нийлүүлэлтийг дэмжсэн. Үүний үр дүнд үл хөдлөх эд хөрөнгийн үнэ өмнөх жилүүдтэй харьцуулахад байршлаас хамааран дунджаар 8.3 хувиар өссөн.


Нийт 205 үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын 1,481 брокер, агентыг нас, хүйс, боловсролын түвшингээр ангилбал:



20 нас хүртэл



21—30 нас



31—40 нас




40 нас дээш



# Статистик үзүүлэлт

Зураг 2. Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагад тусгай зөвшөөрөл олгосон байдал. /Өссөн дүнгээр/



Тайлант хугацаанд буюу 2021 оны эхний хагас жилд 54 хуулийн этгээдээс үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай хүсэлт ирүүлснээс Хороо 38 хуулийн этгээдэд дээрх төрлийн тусгай зөвшөөрөл олгосон бөгөөд нийт 205 хуулийн этгээд тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа эрхэлж байна.


# 1481



## Брокер, агент



Зураг 3. Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын брокер, агентын тоо байршлаар




# 226

## Брокер


# 1255

## Агент

Дархан-Уул, Орхон, Төв аймагт тус бүр 1 үл хөдлөх хөрөнгө зуучлалын байгууллага тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа эрхэлж байна.



## Брокер



## Агент




## Статистик үзүүлэлт



# 289

Хувьцаа эзэмшигч

# 20.0 тэрбум төгрөгийн ХНХ



Хувьцаа эзэмшигчийн бүтэц, бүрэлдэхүүнд гарсан өөрчлөлт




### Хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүн

	2020.И		2021.И
	67 ҮХЭХЗБ	▲ +74	141 ҮХЭХЗБ
	30 ҮХЭХЗБ	▲ +19	49 ҮХЭХЗБ
	3 ҮХЭХЗБ	▲ +8	11 ҮХЭХЗБ
	3 ҮХЭХЗБ	▲ +1	4 ҮХЭХЗБ




## Статистик үзүүлэлт

### Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага үйл ажиллагааны чиглэлээр



### Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага /байршлаар/



Дархан-Уул, Орхон, Төв аймагт үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тус тус 1 хуулийн этгээдэд олгосон байна. Орон нутагт нийт 3 брокер, 3 агент үйл ажиллагаа эрхэлж байна.



# Борлуулалтын тойм

Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагаас 2021 оны эхний хагаст ирүүлсэн тайлан мэдээний ирц




80%

4 сар




79%

5 сар



76%



6 сар




75%

Хагас жил

399	Хэлцлийн тоо	2485
2020.II		2021.II



185	Хэлцлийн тоо	855
2020.II		2021.II




Борлуулалтаас авч буй шимтгэлийн дундаж хувь




10%

2020.II




2.5%

2021.II



63%

2020.II




54%

2021.II



## Борлуулалтын тойм

### Үл хөдлөх эд хөрөнгийн 1 кв-ийн үнийн өөрчлөлт дүүргээр



Үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийг өнгөрсөн оны үнэтэй харьцуулахад Чингэлтэй дүүрэгт үл хөдлөх хөрөнгө 25 хувиар, Сонгинохайрхан дүүрэгт 15 хувиар, Хан-Уул дүүрэгт 8 хувиар өссөн бол Баянгол болон Баянзүрх дүүргүүдэд орон сууцны үнэ 1 хувиар тус тус өссөн.

Монголбанк ипотекийн зээлийн хүүг 2 хувиар бууруулсан нь эрэлтийн талаас үнийг өсгөсөн бол ковид-19 цар тахлын улмаас барилгын бараа материалын хомсдол үүсэж нийлүүлэлтийн талын өсөлтийг өдөөх шалтгаан болсон. Түүнчлэн хотын төвийн дүүргүүдэд үл хөдлөх эд хөрөнгийн үнэ өмнөх онтой харьцуулахад өсөх хандлагатай байна.



## Санхүүгийн тайлангийн үзүүлэлт

### 2020 оны эхний хагас

Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын салбарын нэгтгэлд 103 хуулийн этгээд хамрагдсанаас тайлант хугацааны үзүүлэлтээр 83 хуулийн этгээд, эхлэлтийн тайлангаар 20 хуулийн этгээд хамрагдсан. Тайлант хугацаанд нийт 153 хувьцаа эзэмшигчдийн 1,872,772.0 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй, 10,549,182.1 мянган төгрөгийн нийт хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлж байсан.

Эргэлтийн  
хөрөнгө

62 %

Эргэлтийн  
бус хөрөнгө

38 %

Мөнгөн  
хөрөнгө

22 %

Өр  
төлбөрийн  
хэмжээ

105%

### 2021 оны эхний хагаст

Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын салбарын нэгтгэлд 205 хуулийн этгээд хамрагдсанаас тайлант хугацааны үзүүлэлтээр 153 хуулийн этгээд, эхлэлтийн тайлангаар 52 хуулийн этгээд тус тус хамрагдлаа. Тайлант хугацаанд нийт 289 хувьцаа эзэмшигчдийн 19,972,396.0 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй, 66,072,611.7 мянган төгрөгийн нийт хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлж байна.

Эргэлтийн  
хөрөнгө

52 %

Эргэлтийн  
бус хөрөнгө

48%

Мөнгөн  
хөрөнгө

9 %

Өр төлбөрийн  
хэмжээ

70%

### Тайлант хугацаанд гарсан өөрчлөлтүүд



**11X**

ХНХ-ийн хэмжээ



**6X**

Нийт хөрөнгийн  
хэмжээ



**-30%**

Өр төлбөрийн хэмжээ



## Санхүүгийн тайлангийн үзүүлэлт

Хүснэгт 1. ҮХХЗБ-ын санхүүгийн тайлан мянган төгрөгөөр, хувиар


ҮЗҮҮЛЭЛТ	2020.И	Нийт хөрөнгөд эзлэх хувь	2021.И	Нийт хөрөнгөд эзлэх хувь
<b>ХӨРӨНГӨ</b>				
Эргэлтийн хөрөнгө				
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2,303,725.1	22%	5,969,915.7	9%
Дансны авлага	1,532,819.7	15%	6,414,877.7	10%
Татвар, НДШ – ийн авлага	27,779.3	0%	84,102.9	0%
Бусад авлага	179,348.8	2%	5,844,698.4	9%
Бараа материал	1,753,875.4	17%	12,616,237.3	19%
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	608,440.2	6%	2,486,914.3	4%
Бусад эргэлтийн хөрөнгө	134,412.7	1%	881,323.4	1%
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>6,540,401.1</b>	<b>62%</b>	<b>34,298,419.6</b>	<b>52%</b>
Үндсэн хөрөнгө	3,156,629.3	30%	18,422,009.4	28%
Биет бус хөрөнгө	745,823.2	7%	1,102,401.1	2%
Урт хугацаат хөрөнгө оруулалт	106,328.5	1%	5,791,493.2	9%
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	0.0	0%	5,664,006.5	9%
Бусад эргэлтийн бус хөрөнгө	0.0	0%	720,843.3	1%
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>4,008,781.0</b>	<b>38%</b>	<b>31,774,192.1</b>	<b>48%</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>10,549,182.1</b>	<b>100%</b>	<b>66,072,611.7</b>	<b>100%</b>
Дансны өглөг	5,605,281.8	53%	17,276,425.6	26%
Цалин, татвар, НДШ-ийн өглөг	982,365.8	9%	2,618,628.8	4%
Банкны богино хугацаат зээл	505,412.4	5%	4,292,481.8	6%
Хүүний өглөг	271,083.6	3%	106,084.5	0%
Ногдол ашгийн өглөг	93,452.5	1%	0.0	0%
Урьдчилж орсон орлого	1,569,445.6	15%	6,587,413.0	10%
Нөөц /өр төлбөр/	1,741.7	0%	11,947.9	0%
Бусад богино хугацаат өр төлбөр	771,122.0	7%	9,776,582.8	15%
Борлуулах зорилгоор эзэмшиж буй бүлэг хөрөнгөнд хамаарах өр төлбөр	0.0	0%	65,000.0	0%
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>9,878,325.4</b>	<b>94%</b>	<b>40,734,587.8</b>	<b>62%</b>
Урт хугацаат өр төлбөр	0.0	0%	25,200.0	0%
Урт хугацаат зээл	1,189,145.5	11%	5,049,313.7	8%
Бусад урт хугацаат өр төлбөр	89,339.5	1%	201,378.6	0%
<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>1,282,106.1</b>	<b>12%</b>	<b>5,333,178.5</b>	<b>8%</b>
<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>11,160,431.5</b>	<b>106%</b>	<b>46,067,766.3</b>	<b>70%</b>
Өмч	1,872,772.0	18%	19,972,396.7	30%
- хувийн	1,872,772.0	18%	19,972,396.7	30%
Нэмж төлөгдсөн капитал	12,530.0	0%	12,530.0	0%
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	56,652.0	1%	0.0	0%
Эздийн өмчийн бусад хэсэг	197,462.3	2%	785,374.8	1%
Хуримтлагдсан ашиг	-2,750,669.7	-26%	-765,460.2	-1%
<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>-611,249.3</b>	<b>-6%</b>	<b>20,004,845.4</b>	<b>30%</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>10,549,182.1</b>	<b>100%</b>	<b>66,072,611.7</b>	<b>100%</b>



## Санхүүгийн тайлангийн үзүүлэлт

2020 оны эхний хагас

2021 оны эхний хагас



Мянган төгрөгөөр

Хүснэгт 2. ҮХХЗБ-ын орлого, үр дүнгийн тайлан хувиар

Борлуулалтын орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10 хувиар өссөн бол борлуулсан бүтээгдэхүүний өртөг 11 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Тайлант хугацаанд буюу 2021 оны эхний хагас жилд борлуулсан барааны өртөг нийт орлогын 46 хувийг, борлуулалт маркетингийн зардал болон ерөнхий ба удирдлагын зардал нь нийт орлогын 49 хувийг эзэлж байгаа нь нийт алдагдалд нөлөөлсөн байна.

Үзүүлэлтүүд	2020.I	2021.II	Өөрчлөлт
<b>Нийт орлого</b>	<b>100%</b>	<b>100%</b>	
Борлуулалтын орлого (цэвэр)	88%	98%	10%
Түрээсийн орлого	12%	1%	-11%
Хүүний орлого	0%	0%	0%
Эрхийн шимтгэлийн орлого	0%	0%	0%
Бусад орлого	0%	1%	0%
<b>Нийт зардал</b>	<b>100%</b>	<b>100%</b>	<b>0%</b>
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	35%	46%	11%
Борлуулалт, маркетингийн зардал	8.4%	15%	6%
Ерөнхий ба удирдлагын зардал	56%	34%	-23%
Санхүүгийн зардал	0%	3%	2%
Бусад зардал	0%	3%	3%
Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	352,423.17	-1,306,762.66	



# Эрсдэлийн үнэлгээ

## МУТС ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

	Эрсдэл бага	Дундаж эрсдэлтэй	Эрсдэлтэй
<p><b>Эрсдэл бага</b> Эрсдэлийн үнэлгээгээр 1.1 доош оноо авбал</p>	<p>Эрсдэл бага</p>		
<p><b>Дундаж эрсдэлтэй</b> Эрсдэлийн үнэлгээгээр 1.1– 1.9 оноо авбал</p>	<p>Дундаж</p>		
<p><b>Эрсдэлтэй</b> Эрсдэлийн үнэлгээ 2 болон түүнээс дээш оноо авбал</p>	<p>Эрсдэлтэй</p>		

**Үнэлэх боломжгүй**  
Эрсдэлийн үнэлгээний аль нэг тайланг ирүүлээгүй тохиолдолд

..... 2020 оны хагас жилд МУТС эрсдэлийн үнэлгээ хийгдсэн байгууллагын тоо  
 ..... 2021 оны эхний МУТС эрсдэлийн үнэлгээ хийгдсэн байгууллагын тоо

<p>МУТС эрсдэлийг үнэлэх боломжгүй ҮХХЗБ тоо нэмэгдсэн байна.</p> <p>2020.ИИ: 17 2021.ИИ: 110</p>	<p>МУТС эрсдэл багатай ҮХХЗБ-ын тоо буурсан байна.</p> <p>2020 эхний хагас: 20 2021 эхний хагас: 9</p>	<p>МУТС дундаж эрсдэлтэй ҮХХЗБ-ын тоо буурсан байна.</p> <p>2020 эхний хагас: 62% 2021 эхний эцэс: 41%</p>	<p>МУТС эрсдэлтэй ҮХХЗБ байгууллага байхгүй байна.</p>
---	--	--	--



121

Тайлангийн хариу цахимаар хүргүүлсэн

Тайлант хугацаанд 1 үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагад Улсын байцаагчийн албан шаардлага хүргэсэн.



46

Тайлангийн хариу албан бичгээр хүргүүлсэн





## Дүгнэлт

Тайлант хугацаанд нийт 54 үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагаас тусгай зөвшөөрөл хүсэж холбогдох баримт бичиг ирүүлснээс хууль, журмын нөхцөл шаардлагыг хангасан 38 үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагад тусгай зөвшөөрөл олгосон бөгөөд нийт 205 хуулийн этгээд 226 брокер, 1,255 агенттайгаар үйл ажиллагаа эрхэлж байна. Үүнээс Орхон, Дархан-Уул, Төв аймагт тус бүр 1 үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага үйл ажиллагаа эрхэлж байна.



Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын салбарын 2021 оны эхний хагас жилийн нэгтгэлд 205 хуулийн этгээд хамрагдсанаас тайлант хугацааны үзүүлэлтээр 153 хуулийн этгээд, эхлэлтийн тайлангаар 52 хуулийн этгээд хамрагдсан. Нийт 289 хувьцаа эзэмшигчийн 19,972,396.7 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй, 66,072,611.7 мянган төгрөгийн нийт хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлж байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 11 дахин, нийт хөрөнгийн хэмжээ 6 дахин нэмэгдсэн байна. Нийт хөрөнгөд эзлэх эргэлтийн хөрөнгийн хэмжээ 10 хувиар, өр төлбөрийн хэмжээ 36 хувиар тус тус буурсан үзүүлэлтэй байна.



Тайлант хугацаанд буюу 2021 оны эхний хагас жилд борлуулсан барааны өртөг нийт орлогын 46 хувийг, борлуулалт маркетингийн зардал болон ерөнхий ба удирдлагын зардал нь нийт орлогын 49 хувийг эзэлж байгаа нь нийт алдагдалт нөлөөлсөн байна.



МУТС эрсдэлийн үнэлгээний асуулгыг 2020 оны эхний хагаст 103 ҮХХЗБ ирүүлснээс 20 нь эрсдэл багатай, 64 нь дундаж эрсдэлтэй, 2 нь эрсдэлтэй гэж үнэлэгдсэн бол 17 байгууллагын МУТС эрсдэлийг үнэлэх боломжгүй байжээ. Харин 2021 оны эхний хагаст 205 ҮХХЗБ ирүүлснээс 9 нь эрсдэл багатай, 86 нь дундаж эрсдэлтэй гэж үнэлэгдсэн бол 110 байгууллага МУТС эрсдэлийн үнэлгээний тайланг бүрэн гүйцэд ирүүлээгүй тул үнэлэх боломжгүй байна. Тайлант хугацаанд эрсдэл багатай байгууллага 8 хувиар буурч, дундаж эрсдэлтэй байгууллага 4 хувиар нэмэгдсэн бол эрсдэлийн тайланг үнэлэх боломжгүй байгууллага 44 хувиар өссөн. Энэ нь тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн тоо 50 хувиар өссөнтэй холбоотой байна.







## Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн салбар

Монголбанк 2021 оны эхний хагаст 9.3 тн алтыг 1.3 их наяд төгрөгөөр худалдан авсан. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал алтны худалдан авалт 9 хувиар өссөн хэдий ч худалдаж авсан алтны хэмжээ 14 хувиар буурсан байна. Өөрөөр хэлбэл энэ оны эхний хагаст дэлхийн зах зээл дээрх алтны үнэ өмнөх онтой харьцуулахад тогтмол өссөн байна.

Монголбанкинд алт тушаасан харилцагчид хувиар




Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ




Эх сурвалж: Монголбанкны цахим хуудас

Үндэсний статистикийн хороотой хамтран үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчид, эртний эдлэлийн арилжаа эрхлэгчдийн судалгааг улс даяар 2020 онд хийж гүйцэтгэсэн. Тус судалгаанд нийт 1,253 этгээд хамрагдсан.





Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчид байршлаар



Хөдөө орон нутаг


Улаанбаатар






## Статистик үзүүлэлт


Тайлант хугацаанд 3 хуулийн этгээд, 18 иргэнээс үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэж, холбогдох баримт бичгийг Хороонд ирүүлсэн. Үүнээс 8 хуулийн этгээд, 18 иргэн үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн /ҮМҮЧЭТХЭАЭ/ тусгай зөвшөөрлийг олгосон байна.



Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгосон байдал /өссөн дүнгээр/



Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч иргэн /өссөн дүнгээр/




Үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч иргэн /өссөн дүнгээр/




# Статистик үзүүлэлт

	2020.ИИ		2021.ИИ
	3 хуулийн этгээд	 +23	26 хуулийн этгээд
	5 хуулийн этгээд	 +4	9 хуулийн этгээд
	0 хуулийн этгээд	 +3	3 хуулийн этгээд

Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчид /байршлаар/




Тайлант хугацаанд үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгч 1 иргэн, үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч 3 иргэний тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон.






## Статистик үзүүлэлт

Хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй ҮМҮЧЭТХЭА этгээд, байршлаар



Тайлант хугацаанд Төв аймагт үйл ажиллагаа эрхэлж буй 1 иргэн, Дархан-Уул аймагт үйл ажиллагаа эрхэлж буй 2 иргэн, Сэлэнгэ аймагт үйл ажиллагаа эрхэлж буй 1 иргэнд тус тус үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн тусгай зөвшөөрлийг олгосон байна.









Үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч





## Борлуулалтын тойм

Мянган төгрөгөөр





## Санхүүгийн тайлангийн үзүүлэлт

Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 8 хуулийн этгээд бүрэн нэгтгэлд хамрагдсан бөгөөд 12 хувьцаа эзэмшигчийн 3,463,622.0 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгө, 8,073,760.3 мянган төгрөгийн нийт хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлсэн.

2020 оны  
эхний хагас

Эргэлтийн  
хөрөнгийн дүн

51.4%

Эргэлтийн бус  
хөрөнгийн дүн

48.6%

Мөнгөн  
хөрөнгө

7.4%

Өр төлбөрийн  
хэмжээ

+11.3%

Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 38 хуулийн этгээд нэгтгэлд хамрагдсанаас тайлант хугацааны үзүүлэлтээр 17, эхлэлтийн тайлангаар 21 хуулийн этгээд хамрагдсан. Мөн 57 хувьцаа эзэмшигчийн 8,198,319.0 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгө, 8,458.819.1 мянган төгрөгийн нийт хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлж байна.

2021 оны  
эхний  
хагаст

Эргэлтийн  
хөрөнгийн дүн

72%

Эргэлтийн бус  
хөрөнгийн дүн

28%

Мөнгөн  
хөрөнгө

12%

Өр төлбөрийн  
хэмжээ

71.3%

Тайлант хугацаанд гарсан өөрчлөлтүүд

Эргэлтийн хөрөнгө



Хуримтлагдсан  
ашиг



Үндсэн хөрөнгө



Богино хугацаат өр  
төлбөр





## Санхүүгийн тайлангийн үзүүлэлт

Хүснэгт 3. ҮМҮЧЭТХЭАЭ хуулийн этгээдийн санхүүгийн тайлан /мян.төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	2020.II	Нийт хөрөнгөд эзлэх хувь	2021.II	Нийт хөрөнгөд эзлэх хувь
<b>ХӨРӨНГӨ</b>				
Эргэлтийн хөрөнгө				
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	596,488.45	7%	3,254,368.99	12%
Дансны авлага	1,656,083.90	21%	3,463,536.51	12%
Татвар, НДШ – ийн авлага	2,948.90	0%	248,287.47	1%
Бусад авлага	620,000.00	8%	1,380,243.40	5%
Бусад санхүүгийн хөрөнгө	77,906.80	1%	-	0%
Бараа материал	1,115,481.70	14%	7,848,849.98	28%
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	81,882.30	1%	2,194,872.62	8%
Бусад эргэлтийн хөрөнгө	1,373.50	0%	202,436.52	1%
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	0.00	0%	1,331,425.09	5%
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>4,152,165.55</b>	<b>51%</b>	<b>19,924,020.58</b>	<b>72%</b>
Үндсэн хөрөнгө	3,871,399.00	48%	7,120,855.98	26%
Биет бус хөрөнгө	3,819.10	0%	241,170.90	1%
Урт хугацаат хөрөнгө оруулалт	46,376.60	1%	-	0%
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	0.00	0%	574,432.70	2%
Хойшлогдсон татварын хөрөнгө	0.00	0%	1,070.80	0%
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>3,921,594.70</b>	<b>49%</b>	<b>7,937,530.38</b>	<b>28%</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>8,073,760.25</b>	<b>100%</b>	<b>27,861,550.95</b>	<b>100%</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>				
Дансны өглөг	3,098,844.50	38%	3,656,556.79	13%
Цалингийн өглөг	11,925.20	0%	61,425.65	0%
Татварын өр	292,567.10	4%	448,713.35	2%
НДШ - ийн өглөг	15,603.50	0%	9,246.22	0%
Банкны богино хугацаат зээл	3,477,610.50	43%	1,668,532.40	6%
Хүүний өглөг	785,848.40	10%	98,229.80	0%
Урьдчилж орсон орлого	380.00	0%	4,468,085.60	16%
Нөөц /өр төлбөр/	0.00	0%	13,348.40	0%
Бусад богино хугацаат өр төлбөр	951,236.20	12%	4,479,973.86	16%
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>8,634,015.40</b>	<b>107%</b>	<b>14,904,112.07</b>	<b>53%</b>
Урт хугацаат өр төлбөр	0.00	0%	324,400.50	1%
Урт хугацаат зээл	349,029.80	4%	4,685,583.06	17%
Бусад урт хугацаат өр төлбөр	0.00	0%	177,481.30	1%
<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>349,029.80</b>	<b>4%</b>	<b>4,863,064.36</b>	<b>17%</b>
<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>8,983,045.20</b>	<b>111%</b>	<b>19,767,176.43</b>	<b>71%</b>
Өмч	3,463,622.00	43%	8,458,819.00	30%
- хувийн	3,463,622.00	43%	8,458,819.00	30%
Нэмж төлөгдсөн капитал	0.00	0%	2,278,232.10	8%
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	0.00	0%	250,855.80	1%
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	0.00	0%	15,955.33	0%
Эздийн өмчийн бусад хэсэг	380,592.60	5%	1,686,351.33	6%
Хуримтлагдсан ашиг	-4,753,499.55	-59%	-	-16%
<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>-909,284.95</b>	<b>-11%</b>	<b>8,094,374.52</b>	<b>29%</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>8,073,760.25</b>	<b>100%</b>	<b>27,861,550.95</b>	<b>100%</b>



## Санхүүгийн тайлангийн үзүүлэлт

Орлого үр дүнгийн тайлангийн зарим үзүүлэлт /мянган төгрөгөөр/



Түрээсийн орлого



Борлуулалт  
маркетингийн  
зардал



Ерөнхий ба  
удирдлагын зардал



Хүснэгт 4. ҮМҮЧЭТХЭАЭ-ийн орлого, үр дүнгийн тайлан хувиар









Үзүүлэлт	2020.И	2020.ИИ
Нийт орлого	100%	100%
Борлуулалтын орлого (цэвэр)	75%	98%
Түрээсийн орлого	21%	1%
Хүүний орлого	3%	0%
Ногдол ашгийн орлого	0%	0%
Эрхийн шимтгэлийн орлого	0%	0%
Бусад орлого	1%	0%
Нийт зардал	100%	100%
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	11%	37%
Борлуулалт, маркетингийн зардал	47%	8%
Ерөнхий ба удирдлагын зардал	39%	51%
Санхүүгийн зардал	2%	3%
Бусад зардал	1%	0%
Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)	-1,290,817.70	-2,732,097.42

Тайлант хугацаанд буюу 2021 оны эхний хагас жилд борлуулсан барааны өртөг нийт орлогын 37 хувийг, борлуулалт маркетингийн зардал болон ерөнхий ба удирдлагын зардал нь нийт орлогын 59 хувийг эзэлж байгаа нь нийт алдагдалт нөлөөлсөн байна.



## Эрсдэлийн үнэлгээ

### МУТС ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

 <p>Эрсдэл бага Эрсдэлийн үнэлгээгээр 1.1 доош оноо авбал</p>	<div style="border: 1px solid green; padding: 2px; display: inline-block;">2</div> 
 <p>Дундаж эрсдэлтэй Эрсдэлийн үнэлгээгээр 1.1– 1.9 оноо авбал</p>	<div style="border: 1px solid orange; padding: 2px; display: inline-block;">5</div> 2020.ИИ <div style="border: 1px solid orange; padding: 2px; display: inline-block; width: 150px;">19</div> 2021.ИИ 
 <p>Эрсдэлтэй Эрсдэлийн үнэлгээ 2 болон түүнээс дээш оноо авбал</p>	<div style="border: 1px solid red; padding: 2px; display: inline-block;">1</div> 2020.ИИ <div style="border: 1px solid red; padding: 2px; display: inline-block;">1</div> 2021.ИИ 
 <p>Үнэлэх боломжгүй Эрсдэлийн үнэлгээний аль нэг тайланг ирүүлээгүй тохиолдолд</p>	<div style="border: 1px solid teal; padding: 2px; display: inline-block;">1</div> 2020.ИИ <div style="border: 1px solid teal; padding: 2px; display: inline-block; width: 150px;">18</div> 2021.ИИ 

2020 оны эхний хагаст 8 үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч хуулийн этгээдийн МУТС эрсдэлийн үнэлгээг хийсэн. 2021 оны эхний хагаст нийт 38 үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч хуулийн этгээдийн МУТС эрсдэлийн үнэлгээг хийлээ. МУТС эрсдэлийн үнэлгээг хийх боломжгүй хуулийн этгээд 17-оор, эрсдэлтэй гэж үнэлэгдсэн хуулийн этгээд 1-ээр тус тус нэмэгджээ.

Тайланг хугацаанд 1 үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийг тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа эрхэлж байсан тул торгууль ногдуулсан.



# 17

Этгээдэд тайлан мэдээг гаргах зөвлөмжийг хүргүүлсэн



# 13

Тайлангийн хариуг албан бичгээр хүргүүлсэн



## ДүГНЭЛТ



2021 оны эхний хагас жилд үнэт металл, үнэт чулууны эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч 8 хуулийн этгээд, 20 иргэнд тусгай зөвшөөрөл олгосон. Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн 74 хувь нь Чингэлтэй дүүрэгт үйл ажиллагаа эрхэлж байна. Сэлэнгэ аймагт 20, Баянхонгор аймагт 14, Төв аймагт 12, Өмнөговь аймагт 8 иргэн тус тус үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхэлж байна. Мөн тайлант хугацаанд 4 иргэний тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон.



Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч нь 2021 оны 2 дугаар улиралд 260,914,034.0 мянган төгрөгтэй тэнцэх хэмжээний алтыг худалдан авч 14,875,533.0 мянган төгрөгтэй тэнцэх хэмжээний алтыг тушаасан байна. 2021 оны 2 дугаар улиралд 236,062.0 мянган төгрөгтэй тэнцэх хэмжээний мөнгийг худалдан авч, 104,720.0 мянган төгрөгтэй тэнцэх хэмжээний мөнгийг худалдсан.

Мөн 1,824,558.0 мянган төгрөгтэй тэмцэх хэмжээний үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийг худалдан авч, 2,564,232 мянган төгрөгтэй тэмцэх үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийг худалдсан.



2020 оны эхний хагаст 8 хуулийн этгээдийн нийт орлого 800,000.0 мянган төгрөг байсан бол 2021 оны эхний хагаст 38 хуулийн этгээдийн нийт орлого 7,900,000.0 мянган төгрөгт хүрсэн байна. 2020 оны эхний хагаст нийт орлогын 75 хувийн борлуулалтын орлого эзэлж байсан 2021 оны эхний хагаст нийт орлогын 98 хувийг борлуулалтын орлого эзэлж байна. 2020 оны эхний хагаст нийт зардлын 49 хувийг маркетингийн зардал, 39 хувийг ерөнхий ба удирдлагын зардал эзэлж байсан бол 2021 оны эхний хагаст ерөнхий ба удирдлагын зардал 51 хувийг, борлуулсан бүтээгдэхүүний өртөг 37 хувийг тус тус эзэлж байна. Тайлант үеийн цэвэр ашиг/алдагдал/ өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2,5 дахин өссөн байна.



2020 оны эхний хагаст 8 хуулийн этгээдийн эрсдэлийн үнэлгээг боловсруулсан бөгөөд 2 нь эрсдэл багатай, 5 нь дундаж эрсдэлтэй, 1 хуулийн этгээдийн хувьд үнэлэх боломжгүй гэж үнэлэгджээ. 2021 оны эхний хагаст 38 хуулийн этгээдийн эрсдэлийн үнэлгээг боловсруулснаас нь дундаж эрсдэлтэй 19, эрсдэлтэй 1, үнэлэх боломжгүй 18 хуулийн этгээд байна.



## Нэгдсэн дүгнэлт



Тайлант хугацаанд СББМҮҮ эрхлэгчдээс нийт 107 тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийн хүсэлт ирүүлснээс 38 үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага, үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч 8 хуулийн этгээд, 20 иргэнд тусгай зөвшөөрөл олгосон. Мөн 4 иргэний үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон байна.

Хорооны 2020 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 152 дугаар тогтоолоор “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын мэргэжлийн холбоонд тавигдах шаардлагыг тодорхойлох журам”-ыг баталсан.



Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын салбарын нэгтгэлд 205 хуулийн этгээд хамрагдсанаас тайлант хугацааны үзүүлэлтээр 153 хуулийн этгээд, эхлэлтийн тайлангаар 52 хуулийн этгээд хамрагдсан. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 38 хуулийн этгээд нэгтгэлд хамрагдсанаас тайлант хугацааны үзүүлэлтээр 17, эхлэлтийн тайлангаар 21 хуулийн этгээд хамрагдсан байна. Мөн 2021 оны 1-6 дугаар саруудад зохицуулалтад хамаарах иргэн хуулийн этгээдээс нийт 2,344 сарын мэдээ ирүүлснийг хянан баталгаажуулсан. Үндсэн үйл ажиллагаатай холбоотой сар бүрийн мэдээг дунджаар 160 үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага, 130 үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч нар тогтмол ирүүлж байна.



Тайлант хугацаанд 205 ҮХХЗБ нь нийт 470,454.47 м.кв талбай, 328,364,762 мянган төгрөгийн үнэ бүхий үл хөдлөх хөрөнгийг зуучлан худалдан, худалдан авч, шилжүүлсэн бол 82,060.9 м.кв үл хөдлөх хөрөнгийг 8,091,947.6 мянган төгрөгөөр хөлслүүлж, түрээслүүлэх үйл ажиллагааг зуучилсан байна. Мөн Хорооноос тусгай зөвшөөрөл олгосон 205 ҮХХЗБ нь 66 тэрбум төгрөгийн нийт хөрөнгөтэй, 19,9 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй ба цэвэр ашиг /алдагдал/ -1,3 тэрбум төгрөгт хүрчээ.



Үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийг өнгөрсөн оны үнэтэй харьцуулахад Чингэлтэй дүүрэгт үл хөдлөх хөрөнгө 25 хувиар, Сонгинохайрхан дүүрэгт 15 хувиар, Хан-Уул дүүрэгт 8 хувиар өссөн бол Баянгол болон Баянзүрх дүүргүүдэд орон сууцны үнэ 1 хувиар тус тус өссөн.



## Нэгдсэн дүгнэлт



Тайлант хугацаанд үнэт металл, үнэт чулууны, арилжаа эрхлэгчид 260,914,034 мянган төгрөгийн алт худалдан авч, 320,741,765 мянган төгрөгийн алт худалдсан бол 517.4 сая төгрөгийн мөнгө худалдаж, 236,062 мянган төгрөгийн мөнгө худалдан авч, 104,720 мянгөн төгрөгийн мөнгө худалдсан байна. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арижлаа эрхлэгч нь тайлант хугацаанд 1,824,558 мянган төгрөгийн үнэт эдлэлийг худалдан авч, 2,564,323 мянган төгрөгийн үнэт эдлэлийг худалдсан байна.



Тайлант хугацаанд нэр бүхий 46 ҮХЭХЗБ, 13 ҮМҮЧЭТХЭАЭ хуулийн этгээд 2020 оны жилийн эцсийн тайланг ирүүлээгүй тул мэдэгдэл, 1 ҮХЭХЗБ-д Улсын байцаагчийн албан шаардлагыг хүргүүлсэн. Мөн үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа эрхэлж буй 1 хуулийн этгээдэд зөрчлийн хэрэг нээж торгууль оногдуулсан бол үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлгүй эрхэлсэн байж болзошгүй 1 хуулийн этгээдэд зөрчлийн хэрэг нээн зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж байна.